



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/48

Мөрөн сум

Өвс, тэжээлийг сумдад олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.3, 32.1.12, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 сарын 01-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн ихэнх нутгаар цасан бүрхүүл тогтож зарим сумдад хүйтний хэм өдөртөө 25-38, шөнөдөө 35-40 хэм хүртэл хүйтэрснээс малын хорогдол ихээр гарч өвөлжилт хүндэрсэн, сумдын ажлын хэсэг газар дээр нь зудын эрсдэлийн үнэлгээ хийснээр их эрсдэлтэй 8 сум, дунд эрсдэлтэй 7 сум үнэлэгдсэний дагуу аймгийн Онцгой комиссын шийдвэрийг үндэслэн сумын өвөлжилтийн мэдээллийг нэгдүгээр, өвс олгох хуваарийг хоёрдугаар, ногоон тэжээл олгох хуваарийг гуравдугаар, хивэг олгох хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хуваарийн дагуу өвс, ногоон тэжээл, хивэг олгохыг Мал хамгаалах сангийн менежер, нярав (Д.Эрдэнэбилэг)-т хариуцуулсугай.

3. Өвс, ногоон тэжээл, 2022 онд бэлтгэсэн хивгийг дансны үндсэн үнээр, 2021 онд бэлтгэсэн хивгийг 14.000 (арван дөрвөн мянга) төгрөгөөр тооцон, Мал хамгаалах сангийн холбогдох дансанд төвлөрүүлж тайлагнаж ажиллахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч (Ч.Хишигсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Олгогдсон өвс, хивэг, ногоон тэжээлийн үнийг Мал хамгаалах сангийн дансанд төвлөрүүлж, малчдад тэгш хуваарилан олгох, 2020 онд авсан өвс, тэжээлийн тооцоог 2023 оны эхний улиралд бүрэн барагдуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Сумдад олгох өвсийг хуваарийн дагуу олгох ажилд хяналт тавьж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр) -д үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болсугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2023 оны  
02 дугаар сарын 03-ны өдрийн  
А.М.Б дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт

МАЛ АЖ АХУЙН ӨВӨЛЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Сумын нэр	2022 он жилийн эцсийн малын тоо	Малын зүй бүс хорогдлын тоо	Эрсдэлийн үнэлгээ
1	Алаг-Эрдэнэ	243426	515	Их
2	Арбулаг	454448	625	Дунд
3	Бүрэнтогтох	428393	400	Их
4	Галт	426783	667	Их
5	Жаргалант	276428	824	Дунд
6	Мөрөн	263426	146	Дунд
7	Рашаант	269922	337	Дунд
8	Ренчинлхүмбэ	219206	205	Их
9	Тосонцэнгэл	367141	62	Дунд
10	Төмөрбулаг	376562	108	Их
11	Улаан-Уул	236169	60	Их
12	Хатгал	53396	30	Дунд
13	Цагаан-Нуур	28553	68	Их
14	Цэцэрлэг	329086	100	Их
15	Шинэ-Идэр	233741	325	Дунд
	Нийт	4206680	4472	Их -8, Дунд-7

Тайлбар: Энэ хуваарийг хийхэд дараах зарчим баримталлаа.

- Сумын Засаг даргын албан тоот
- Эрсдэлийн үнэлгээг хийсэн байдал, эрсдэлийн түвшин
- Мал хамгаалах сангийн өр авлагатай эсэх
- Малчин өрхөд ногоон тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулалт

Аймгийн Засаг даргын 2023 оны  
02 дугаар сарын 03-ны өдрийн  
А./Ч.З. дугаар захирамжийн  
хоёрдугаар хавсралт

### СУМДАД ОЛГОХ ӨВСНИЙ ХУВААРЬ

№	Сумын нэр	Сумаас ирүүлсэн санал	Батлагдсан хуваарь
		Өвс /боодол/	Өвс /боодол/ 9181/183,6тн
1	Алаг-Эрдэнэ	100	100
2	Арбулаг	600	500
3	Бүрэнтогтох	1500	800
4	Галт	400	400
5	Жаргалант	2500	1000
6	Мөрөн	1000	500
7	Рашаант	2000	800
8	Ренчинлхүмбэ	2000	0
9	Тосонцэнгэл	1000	800
10	Төмөрбулаг	2500	1000
11	Улаан-Уул	8000	0
12	Хатгал	600	500
13	Цагаан-Нуур	500	0
14	Цэцэрлэг	1000	500
15	Шинэ-Идэр	2500	800
Нийт	Боодол	25200	7700
	тн	504тн	154тн
МХС-ийн үлдэгдэл	Боодол		1481
	тн		29.6 тн

\_\_\_оОо\_\_\_



Аймгийн Засаг даргын 2023 оны  
2-дүгээр 2 сарын 03-ны өдрийн  
А/03 дугаар захирамжийн хавсралт

СУМДАД ОЛГОХ НОГООН ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Сумын нэр	Сумаас ирүүлсэн санал	Батлагдсан хуваарь
		Ногоон тэжээл /боодол/	Ногоон тэжээл /боодол/
1	Арбулаг	200	200
2	Бүрэнтогтох	1500	1300
3	Рашаант	2000	500
4	Тосонцэнгэл	800	500
5	Хатгал	200	200
6	Цэцэрлэг	1200	1300
Нийт	Боодол	5900	4000
	тн	118 тн	80 тн
МХС-ийн үлдэгдэл	Боодол		3320
	тн		66.4тн



Аймгийн Засаг даргын 2023 оны  
2 дугаар сарын 03-ны өдрийн  
А.148 дүгээр захирамжийн дөрөвдүгээр  
хавсралт

СУМДАД ОЛГОХ ХИВЭГНИЙ ХУВААРЬ

№	Сумын нэр	Сумаас ирүүлсэн санал	Батлагдсан хуваарь	
		Хивэг /шуудай/	2021 оны Хивэг /шуудай/	2022 оны Хивэг /шуудай/
1	Алаг-Эрдэнэ	100		50
2	Арбулаг			41
3	Бүрэнтогтох	200		41
4	Галт		50	50
5	Жаргалант	1600	50	250
6	Мөрөн	400	100	60
7	Рашаант	1000	50	100
8	Ренчинлхүмбэ	800	75	325
9	Тосонцэнгэл		100	50
10	Төмөрбулаг		50	50
11	Улаан-Уул	10000	75	325
12	Хатгал	120	50	
13	Цагаан-Нуур	400	100	50
14	Цэцэрлэг	100	50	50
15	Шинэ-Идэр		50	
Нийт	Боодол	14720	800	1442
	тн	368 тн	20.0тн	36.0 тн

сОо